



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2026 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 267

Жаргалтхаан сум

**С.Доржжагдагийг туршилтын хугацаагаар  
түр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 50 дугаар зүйлийн 50.1.2, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт, "Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"- ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын жижүүр, сахиулаар Содномпилын Доржжагдагийг 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдрөөс эхлэн туршилтын хугацаагаар түр томилсугай.

2.С.Доржжагдагт жижүүр, сахиулын хариуцах ажил үүргийг танилцуулж, хариуцах эд хөрөнгийг хүлээлгэн өгөхийг нярав Д.Мөнхбаярт даалгасугай.

3.Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажиллахыг С.Доржжагдагт үүрэг болгосугай.

4.Жижүүр, сахиул С.Доржжагдагийн ТҮ-1 дэх шатлал 954,000 (Есөн зуун тавин дөрвөн мянга) төгрөгөөр цалинжуулж, орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч Т.Энхсайханд зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.МӨНХДЭЛГЭР

Data (D:) /A4 tushaal/